



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 03 сарын 26 өдөр

Дугаар А/32

Дадал сум

**Эрсдэлийн сангаас зардал гаргах
тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын Балж багийн Сөөгтэй гэх газарт 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдөр гарсан хээрийн түймэр, Агац багийн Сантхааны давааны ар гэх газарт 2025 оны 03 дугаар сарын 08-ны өдөр гарсан хээрийн түймэрт ажилласан албан хаагчдын хоол хүнс болон тээвэр шатахууны зардал гаргасугай.

2.Нийт зардлын 1,194,930 (Нэг сая нэг зуун ерэн дөрвөн мянга есөн зуун гуч) төгрөгийг эрсдэлийн сангаас гарган зарцуулахыг нягтлан бодогч (С.Нандинцэцэг)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн албаны дарга (Д.Агаармандал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.МӨНХХУЯГ

010000109